

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ
ЭСЭХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 05 дугаар
сарын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайхан

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг дэмжих, бизнесийн идэвхжилийг нэмэгдүүлэх, өргөжих нөхцөлийг бүрдүүлэх, бичил, жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн татварын илүү хялбар, таатай орчныг бүрдүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын бизнесийн орчны олон улсын тавцанд өрсөлдөх чадвар сайжирч жижиг, дунд бизнес эрхлэгчдийн татварын ачаалал буурах, улмаар эдийн засгийн өсөлт нэмэгдэж нийгмийн тогтвортой байдлыг бэхжүүлэх суурь нөхцөл бүрдэх, аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа тогтвортой өргөжүүлэн хөгжүүлэх, санхүүгийн чадавхаа бэхжүүлэх, бизнесийн идэвхээ нэмэгдүүлж дотоод, гадаад зах зээлд өрсөлдөх боломжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой гэж үзсэн байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин хуулийн төсөлд татвар ногдуулах орлогын босгыг нэмэгдүүлж 6-10 тэрбумын орлоготой аж ахуйн нэгжүүд 25 хувиар татвар төлөхөөр тусгагдсан нь хэдэн аж ахуйн нэгжийн татварын ачаалал хэдий хэмжээгээр буурч байгаа болон виртуал бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 100 хувь хөнгөлөхөд хамрагдах аж ахуйн нэгжүүдийн тоо болон үзүүлэх хөнгөлөлтийн дүнгийн талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд үг хэлээгүй болно.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн

олонх буюу 68.8 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Н.НАРАНБААТАР